



ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД



giz



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

📍 Монгол Улс, Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг,
15-р хороо, Махатма Гандигийн гудамж, МҮХАҮТ-ын байр

☎ (+976) 77277070

✉ chamber@mongolchamber.mn

🌐 www.mongolchamber.mn

📘 mongolchamber

🌐 www.trademongolia.mn

🐦 mongolchamber



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ХУДАЛДААНЫ ГАЗАР



УВС АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМ

БИЗНЕСИЙН СЭРГЭЛТ



2024.04.26-27

Увс аймаг, Улаангом хот



МЭНДЧИЛГЭЭ

Бизнесийн сэргэлт-баруун бүс арга хэмжээнд оролцогч аж ахуйн нэгж байгууллагууд, бизнес эрхлэгчид та бүхний амар амгаланг эрэн мэндчилье.

МҮХАҮТ-аас 2024–2027 онд хувийн хэвшлийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх, бизнес эрхлэх хууль эрх зүйн орчинг сайжруулах, төр хувийн хэвшлийн үр дүнтэй түншлэлийг хөгжүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн. МҮХАҮТ-аас энэхүү арга хэмжээний хүрээнд Олон улсын худалдааны төв (ИТС)-ийн эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих олон улсын “SheTrades” төвийн ажиллагаа, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнесийг дэмжих, тэдний ялгарлыг бий болгох “Woman owned” тохирлын тэмдэг, Харвард менежмент ментор хөтөлбөр болон залуучуудад бизнесийн боловсрол олгох Р-МВА хөтөлбөрийг танилцуулах, хөтөлбөрийн зарим сэдвийг та бүхэнтэй хуваалцах болсондоо баяртай байна.

МҮХАҮТ нь 1999 оноос аймгуудад Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимуудыг байгуулж, орон нутгийн бизнес эрхлэгчдийн чадавхийг бэхжүүлэх, жижиг дунд бизнесүүдийг дэмжих төслүүд хэрэгжүүлэх, төр хувийн хэвшлийн хэлэлцлийн оновчтой механизмыг бий болгон хөгжүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн. Баруун 5 аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимууд 1999–2005 онуудад байгуулагдсан бөгөөд одоогийн байдлаар нийт 400 гаруй гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Танхимууд гишүүнчлэлийн хувьд өргөжин тэлэх нь бизнес эрхлэгчдийн санал дуу хоолой хүчтэй болж шийдвэр гаргах түвшинд нөлөөлөл нэмэгдэх төдийгүй бизнес хоорондын хамтын ажиллагааны сүлжээ өргөжих, бизнесийн түншлэлийг хөгжүүлэхэд ихээхэн үр нөлөөтэй. Бизнес эрхлэгч та бүхний өмнө Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын үүд үргэлж нээлттэй байх болно.

Баруун бүсийг хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангахад бизнес орчныг сайжруулах, төр хувийн хэвшил хамтран ажиллах, түүнчлэн хөрш орнуудын бизнес эрхлэгчидтэй харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал бөгөөд энэ чиглэлийн санал санаачилгыг МҮХАҮТ-ын зүгээс дэмжин ажиллахаа илэрхийлж байна.

Та бүхэнд амжилт, сайн сайхныг хүсье.



МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын “Алсын хараа 2050”, 2020–2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт суурилсан Увс аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаад гурав гаруй жил болж байна.

2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ “Орлогын бүтээн байгуулалт” уриалга гарган иргэдээ сэдэлжүүлж төрийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдүүлж иргэдээс гарах зардлыг бууруулах, баялаг бүтээгч, бизнес эрхлэгчдийг шаардлагатай дэд бүтэц, техник тоног төхөөрөмж, санхүүгийн эх үүсвэр, маркетинг менежментээр дэмжин шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх брэнд хөгжүүлэлтэд суурилсан ажлын байр бий болгох кластерийг хөгжүүлж орлого бүтээж ажиллалаа.

Увс аймгийн нөөцөд суурилсан эдийн засгийн бие даан байдлыг хангах “Олон улсын худалдаа тээвэр логистик”, “Баруунтуруун ХАА-н цогцолбор”, Хөдөөгийн сэргэлт төвлөрлийг сааруулах “Шинэ суурьшлын бүс”, Олон улсын глобал сургуульд суурилсан шинэ хотын төлөвлөлтийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан тооцоо судалгааг хийх, хөрөнгө оруулалтыг татах ажлыг эхлүүлээ.

Монгол Улсын Засгийн газрын “Боомтын сэргэлт” бодлогын хүрээнд баруун бүсийн аймгуудын боомтуудад өргөтгөл шинэчлэл хийгдэж байгаа энэ үед “Хөдөөгийн сэргэлт-Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Эдийн засгийн хөгжлийн яам, Хөрөнгө оруулалт, худалдааны газар, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран Увс аймгийн Засаг даргын тамгын газар “Бизнесийн сэргэлт-Баруун бүсэд” Олон улсын арга хэмжээг анх удаа зохион байгуулж байна. Уг арга хэмжээ нь бүс нутгийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, хил орчмын Улсуудын бизнес, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргасан, харилцан үр ашигтай хөрөнгө оруулалтыг бий болгох чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Баруун бүс нутагт орлого бий болгох хил дамнанас бүс нутгийн эдийн засгийн форумыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан ЭЗХЯ, ХОХГ, МҮХАҮТ-ын удирдлага хамт олонд Увс нутгийнхаа бүтээлч иргэдийн нэрийн өмнөөс баярласнаа илэрхийлж байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.



МЭНДЧИЛГЭЭ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөрөнгө оруулалт, худалдааны газар нь Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын

хүрээнд хөрөнгө оруулалт, худалдааны холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулагчдын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, дэмжлэг үзүүлэх, импортыг орлох салбарыг хамгаалах, экспортыг дэмжих зэрэг үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Манай байгууллага хөрөнгө оруулалт, худалдааг дэмжих ажлын хүрээнд зохион байгуулж буй “Бизнесийн сэргэлт–Баруун бүс” олон улсын арга хэмжээнд оролцож буй Оросын Холбооны Улсын төр захиргааны байгууллага, мужуудын салбар танхимууд, Увс, Ховд, Баян–Өлгий, Завхан, Говь–Алтай аймгийн салбар танхимууд болон бизнес эрхлэгчиддээ мэндчилгээ дэвшүүлж байна.

Энэ арга хэмжээ нь Засгийн газраас Бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал хэлэлцэгдэж буй болон мөн худалдааны түнш орнуудтай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр болон чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар хэлэлцэж байгаа энэ цаг үед зохион байгуулагдаж байгаагаараа онцлог болж байна.

Засгийн газраас баримталж буй худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн орчинг сайжруулах бодлогыг дэмжин хэрэгжүүлэх, үндэсний үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг олон улсын зах зээлд гаргахад манай байгууллага байнга дэмжин ажиллана.

“Бизнесийн сэргэлт–Баруун бүс” арга хэмжээний үр дүнд хоёр орны бизнес эрхлэгчид маань харилцан үр ашигтай бизнесийн гэрээ хэлэлцээр амжилттай байгуулж, хамтын ажиллагааг хөгжүүлэх, цаашлаад баруун бүс нутгийн эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, орон нутаг хоорондын харилцаа, хамтын ажлыг бэхжүүлэх, бүс нутгуудтай эдийн засгийн интеграцийг өргөжүүлэх, гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

“Бизнесийн сэргэлт – Баруун бүс” арга хэмжээнд оролцогч та бүхний бизнесийн үйл ажиллагаа улам өргөжин дэвшиж, амжилтаар дүүрэн байхыг хүсье.

Хөрөнгө оруулалт, худалдааны газрын дарга **В.ЭНХБААТАР**

SheTrades Mongolia Hub

Эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах нь дэлхийн хөгжлийн хөтөлбөрийн чухал сэдэв байсаар ирсэн. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг худалдаагаар дамжуулан нэмэгдүүлэх нь зөвхөн төрийн бодлого, хувийн хэвшил, нийгмийн асуудал биш юм. Тиймч учраас Дэлхийн худалдааны байгууллага (WTO), Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) хамтарсан агентлаг болох Олон улсын худалдааны төв нь эмэгтэйчүүдийн болон худалдааны тэргүүлэх хөтөлбөр болох SheTrades санаачлагыг эхлүүлсэн юм.

ОУХТ–ын дэргэдэх SheTrades Hub нь өдгөө дэлхийн 17 улсад байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. 2023 оны 6 дугаар сард дэлхийн 14 дэхь SheTrades Hub Монгол улсад албан ёсоор Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимыг түшиглэн нээгдсэн.

SheTrades Mongolia Hub нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг олон улсын болон дотоодын бизнесүүдтэй түншлэлийн харилцаа үүсгэх, харилцан туршлага солилцох, чадавхжуулах, хөрөнгө оруулалт, санхүүгийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд нэвтрэх, тогтвортой үйл ажиллагаа явуулахад гүүр болж ажиллах зорилготой.

SheTrades Mongolia Hub–д нэгдсэнээр:

- Олон улсын худалдааны төвийн дэргэдэх SheTrades Hub–д бүртгэлтэй албан ёсны гишүүн болох,
- Олон улсын худалдааны төвийн цахим сургалтуудад хамрагдах боломж,
- Дэлхийн 17 улсын SheTrades Hub–уудтай хамтын ажиллагаа, түншлэл үүсгэх боломж,
- ОУХТ–ын түнш байгууллагуудын сургалтад хамрагдаж суралцах, мэргэших боломж,
- Дотоодын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдтэйгээ хамтын ажиллагаа эхлүүлэх,
- Маркетинг борлуулалтаа өсгөх,
- Олон улсын үзэсгэлэнд оролцож бараа бүтээгдэхүүнээ сурталчлах
- Харилцан туршлага судлах зэрэг маш олон боломжуудыг бий болгох юм.

Та дараах QR уншуулан SheTrades Mongolia төвтэй нэгдээрэй.



Холбоо барих:

Утас: 77277070

Имэйл хаяг: project@mongolchamber.mn

Facebook хуудас: SheTrades Mongolia Hub

Вебсайт: shetrades.mongolchamber.mn

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, 17011, Хан–Уул дүүрэг, 15–р хороо, Махатма Гандигийн гудамж, МҮХАҮТанхимын байр, УБ шуудан – 10

ЭКСПОРТ, ИМПОРТЫН МЭДЭЭЛЭЛ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас бизнес эрхлэгчдийг гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, олон улсын зах зээл, нэн ялангуяа уул уурхайн бус экспортыг дэмжих, хөгжүүлэх, зах зээлд нэвтрэх чиглэлээр мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах зорилгоор “Экспорт, импортын мэдээлэл, зөвлөгөө өгөх нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг ажиллуулж байна.

Төв нь олон улсын гэрээ хэлэлцээр, гаалийн тариф, тарифын хөнгөлөлт, экспорт хийх үйл явц, гарал үүслийн гэрчилгээ болон Захиалгат мэдээлэл бэлтгэх чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө, төрөлжсөн үйлчилгээг үзүүлнэ.

Утас: 7727-7070, 91919396, 99077127

Цахим шуудан: foreigntrade@mongolchamber.mn

**ЭКСПОРТ
ИМПОРТ**

**МЭДЭЭЛЭЛ ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ
НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

- Хууль эрх зүй
- Бараа бүтээгдэхүүний экспорт хийх үйл явц
- Гадаад худалдааны бичиг баримт бүрдүүлэлт
- Хөнгөлөлтийн Ерөнхий Систем
- Чөлөөт худалдааны хэлэлцээр
- Гаалийн татвар, тарифын хөнгөлөлт, чөлөөлөлт
- Бараа нийлүүлэх нөхцөл, тээвэрлэлт
- Гадаад худалдааны төлбөр, тооцоо
- Хөрөнгө оруулалт
- Сургалт
- Гарал үүсэл, Экспертиз, Бизнес санал

7727-7070 (36) 9191-9396, 9907-7127 foreigntrade@mongolchamber.mn

УВС АЙМАГ

1925 онд Дөрвөд далай хаан, Зоригт хааны аймгийг нэгтгэж Чандмань уулын аймгийг байгуулж, 1931 оны 2 дугаар сарын зургаанд Увс аймгийн хилийн заагийг тогтоосноор Увс аймгийн засаг захиргааны хуваарь үүссэн. Аймгийн төв нь Улаангом, засаг захиргааны нэгжийн хувьд 19 сум, 93 багтай, 84.9 мянган хүн амтай. Увс аймаг нь нийслэл Улаанбаатар хотоос 1336 километр, Монгол улсын баруун хойморт Их нууруудын хотгорын хойд хэсэгт өргөрөгийн дагуу сунаж тогтсон 69,6 мянган ам дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй. Баян-Өлгий, Ховд, Завхан аймаг, ОХУ–тай хиллэдэг. Хамгийн нам цэг нь д.т.д 758,9 метрт буй Увс нуурын түвшин, хамгийн өндөр цэг нь д.т.д 4130 метрт өргөгдсөн Мөст оргил юм.

Тус аймгийн нутаг нь далайн төвшнөөс 2400–4130 м өндөр мөнх цаст сүрлэг уулс, 9200 ам дөрвөлжин километр талбай бүхий элсэн манхан, Увс, Хяргас, Айраг, Ачит, Үүрэг, Дөрөө зэрэг томоохон нуурууд, Тэс, Ховд, Хархираа, Түргэн, Хангилцаг, Туруун, Завхан зэрэг томоохон голуудтайгаас гадна алтай, хангай, говь хосолсон байгалийн бүхий л бүс бүслүүрийг багтаасан “Төв Азийн эталон нутаг” юм. Тус аймаг чулуун нүүрс, жамц давс, чацаргана, баяд үүлдрийн хонь, Өлгийн улаан ямаа, Тэс угшлын адуу зэргээрээ Монголдоо алдаршсан. Увс аймаг нь байгалийн үзэсгэлэнт газар олонтой аялал жуулчлал хөгжүүлэх боломжтойгоос гадна газрын хэвлийн нөөц нь бараг хөндөгдөөгүй, газар тариалан эрхлэх соёл уламжлалтай, байгаль цаг уурын эрс тэс уур амьсгал бүхий нөхцөлд дасан зохицсон мал сүрэг, ажилсаг, хөдөлмөрч, оюунлаг иргэдтэй, ажиллах хүчний нөөц сайтай, ОХУ–тай хатуу хучилттай авто замаар холбогдсон зэрэг давуу талуудтай.

УВС НУУР

Монгол орны хамгийн том талбай бүхий Увс нуурын Дархан цаазат газар нь өмнө талаараа Хархираа, Түргэн, Хан хөхийн уулс, хойд талаараа Тагнийн нуруу, зүүн талаараа Бөөрөг дэлийн элсээр хүрээлэгдэн д.т.д 759 м өндөрт 3350 км2 талбайг эзлэн оршино. Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтах ба нуурын урт 84 км, өргөн 79 км, гүн нь 12–22 м зарим газартаа 29 м хүрдэг. Увс нуурын ай сав газар нь нь говь, цөлөрхөг хээр, хээр тал, ойт хээр, уул нуруу, мөнх цас, мөсөн голуудыг багтаасан эрс тэс уур амьсгалтайгаараа онцлог нутаг юм. Европ, Ази тивийн хэмжээнд байгалийн онгон хэлбэрээ хадгалж үлдсэн цөөн газрын нэг бөгөөд дэлхийн усны шувууд дулааны улиралд ирж өндөглөдөг зусдаг гол газар бөгөөд 405 зүйлийн шувууд бүртгэгдсэн байдгаас нэн ховор болон ховор зүйлийн халбагана хошуут, хар өрөв тас, цасч дэглий, борцгор хотон, гангар хун, ямаан сүүлт нугас, реликт цахлай, ухаа шумбуур, цагаан ууль,

усны цагаан сүүлт бүргэд, хээрийн галуу зэрэг шувууд цөөнгүй байдаг төдийгүй манай орны их нууруудын хотгор, Увс нуурын ай сав газарт зусдаг. Увс нуурын ай савын дархан цаазат газрууд нь дэлхийн байгалийн бүс, бүслүүрийн бүхий л шинж төрхийг өөртөө агуулсан нь энэ нутгийг олон улсын ач холбогдол бүхий Төв Азийн эталон нутаг болохыг илтгэж байгаа үзэсгэлэнт газар юм.

Увс нуур нь:

– 1997 онд НҮБ–ынСоёл, шинжлэх ухаан, боловсролын байгууллагын “Хүн ба шим мандал” нөөц газарт

– 2004 онд Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай “Рамсарынконвенци”–д

– 2003 онд “Дэлхийн Байгалийн өв”–д тус тус хамрагдсан.

ДЭГЛИЙ ЦАГААН



Монгол Алтайн нурууны цавчим хаднуудаас үүсэлтэй Түргэний уулсын ноён оргил Дэглий цагаан уул нь далайн төвшнөөс дээш 3978 метр өндөр. Түргэний уулс нь Бөхмөрөн, Сагил сумын нутгийг дамнан 70 орчим км

ЦАГААН ШУВУУТЫН ДАРХАН ЦААЗАТ ГАЗАР

Сагил сумын нутагт Увс нуур, Үүрэг нуурын усан сангийн хагалбарт зүүн хойноос баруун урагш сунаж тогтсон байршилтай, 22 мянган га талбайтай, далайн төвшнөөс дээш 3496 метр өндөр, хэрчигдэл ихтэй, шовх хянга, хад асга бүхий эгц хажуутай. 72 зүйл хөхтөн, 173 зүйлийн жигүүртэн, 2 зүйл мөлхөгчид байдагаас Цоохор ирвэс, Аргаль, Янгир, Халиун буга, Хүдэр зэрэг манай оронд төдийгүй дэлхийд ховор амьтад элбэгтэй өндөр уулын экосистем бүхий байгалийн үзэсгэлэнт газар юм.

ОЛОН НУУР



үргэлжлэх уулс бөгөөд Цагаан дэглий уулаас зүүн тийш Хавцалын боом хүртэлх 145.1 мянган га талбайг хамарна. Цагаан дэглий уул нь ой тайгатай, уулын түргэн урсгалт гол горхиудтай, мөнх цастай, мөсөн голтой, бэлээрээ үзэсгэлэнт нууруудтай, өвөрмөц тогтоц бүхий хадан хясаатай, ховор болон ховордсон ургамал амьтны аймагтай. Энэ уулнаас Түргэн, Буурал, Хархираа, Ямаатын голууд эх авна. Түрэгийн үеийн болон өмнөх үеийн хүн чулуун хөшөөнүүд, хадны сүг зураг, хиргисүүр, булш бунхан, Төгс буянт хийдийн туурь зэрэг түүх соёлын дурсгалуудтай байгалийн үзэсгэлэн бүрдсэн өвөрмөц тогтоцтой газар нутаг юм.



Бөхмөрөн, Ховд сумын нутгийн зааг дээр, далайн төвшнөөс дээш 3000м өндөр Хархираа, Түргэний уулсын дунд том жижиг 108 нуур бий. Энэхүү газрыг “Олон нуур” гэж нэрлэдэг. Мөнх цас, сүрлэг хад уулс, улаан номд орсон нэн ховор ирвэс, аргаль, янгир, буга зэрэг 20 зүйлийн ан амьтан, 30 гаруй зүйлийн ургамалтай. Нуур нь хайруус загастай.

РАШААНТЫН АМНЫ ЭХ

Увс аймгийн Ховд сумын нутаг Олон нуурын зуслангийн зүүн өмнөд хэсэгт нь оршино. Рашааны аманд гурван өнгийн нуур байдаг бөгөөд хамгийн доод талд нь ногоон нуур, дунд нь шар нуур, дээд талд нь улаан өнгийн нуур бий. Ногоон нуурын дээд талд рашаантай, вансэмбэрүү цэцэг элбэг ургадаг. Эдгээр газруудыг 2004 онд улсын тусгай хамгаалалтанд авсан.

ЧАНДМАНЬ УУЛЫН ДУРСГАЛ



Чандмань уул бол Монгол, Төв ази төдийгүй дэлхий дахины хэмжээнд яригдах бие даасан цогцолбор соёлыг агуулсан уул юм. Чандмань

ЗУРААГИЙН ХАДНЫ ЗУРАГ

Увс аймгийн Зүүнхангай сумын төвөөс хойш 14 км–г орших Зураагийн хошууны өвөр талын таван том улаан хадыг “Зураагийн улаан хад” хэмээн нэрлэдэг. Дунд талын хоёр хаданд эртний хүмүүсийн улаан зосоор зурсан зургууд бий. Эдгээрийг шинэ чулуун зэвсгийн

МОЖООГИЙН ХАДНЫ ЗУРАГ

Увс аймгийн Сагил сумын нутагт Цагаан голын эхэнд оршино. Шинэ чулуун зэвсгийн үед хамаарах бөгөөд Монголд төдийгүй дэлхийд гайхагдах зураг дүрслэлтэй. Аргаль, янгир, тэмээ, нохой, үхэр, хүн зэргийг



уул далайн төвшнөөс дээш 1100м өндөр, улаан боржин чулуунаас тогтсон. Эл дурсгал нь хүрэл, төмрийн түрүү үеийн хоёр томоохон иргэншил болох дорнод монголын дөрвөлжин булш, дундад азийн скифийн соёл иргэншлийг холбосон энэ хоёр соёл иргэншлийн агуулгыг аль алиных нь онцлогийг өөртөө агуулсан ихээхэн өвөрмөц онцлог бүхий дурсгал. Төмөр зэвсгийн түрүү үе буюу МЭӨ VII–III зууны үед холбогдох иж бүрэн дурсгал бол Увс аймгийн Улаангом хотын дэргэдэх Чандмань ууланд буй цогцолбор соёл юм.

үед холбогдох дурсгал хэмээн тодорхойлсон байдаг. Мөн овог отгоороо ан хийж буй дүрслэл бий. Дэлхий дээр ийм утга агуулгатай зураг 2 байдаг бөгөөд нөгөө нь Америкийн Аляскад байдаг байна.

дүрсэлсэн бөгөөд Хойд цэнхэрийн агуйн зургийн адил түүхийн үнэ цэнийг агуулдаг. Үхрийг нум сумаар харваж байгаа болон хөтлөн явж байгаа хүний дүрслэл буй.

МӨНГӨТ ЦАХИР



Давст сумын төвөөс 50 орчим км-г цагаан саарал өнгийн шохойн гантиг чулуунаас

тогтсон мөнгөлөг цагаан өнгөтэй д.т.д 1600 метр өндөрт орших уулыг Мөнгөт цахир уул гэдэг. Энэхүү уул нь шохойн чулуу, боржин өнгө алагласан, хад цохион дээр нь ургасан гацуурт ойтой, өвөрмөц тогтоц, үзэсгэлэн хосолсон байгаль эхийн бүтээсэн үнэт ховор дурсгал юм. Ховор нандин дурсгал, өвөрмөц тогтоцтойгоос гадна түүхийн дурсгалт газарт холбогдох сүг зураг, агуйтай. Уулын аманд байрлах сүг зурагт буга, янгир ямаа, олон тооны тамга тэмдгээс гадна хүний нүүрийг дугуйд багтаан хөмсөг, нүд, хамар, амтай дүрсэлсэн байдаг.

ХЯРГАС НУУР

Увс аймгийн Завхан, Наранбулаг, Цагаанхайрхан, Малчин, Хяргас сумын нутаг Их нууруудын хотгорт, Ханхөхий нурууны урд хэсэгт оршдог. Нуурын гадаргын талбай нь 1407 км², урт нь 75 км, өргөн нь 31 км, дундаж өргөн нь 19 км, усны мандал нь д.т.д 1028 метр өндөрт оршино. Тус нуур нь тектоник гаралтай нуур учраас эргээс 10–20м гүн рүү ороход 40–50 метр хүртэл гүнзгий болох ба хамгийн гүнзгий хэсэг буюу Чацарганы шугам орчимд 80 метр хүрнэ. Хяргас нуурын урд хөвөөнд таваг чулууны булаг, хойд хэсэгт Чоно долоохын булаг, Могойн булаг зэрэг эм



эмчилгээний зориулалттай рашаан сувиллууд олон бий.

ХЭЦҮҮ ХАД



Аймгийн төвөөс зүүн урагш 230 километр, Завхан сумаас 60 километр зайд Хяргас нуурын зүүн хэсэгт усан доогуур 5–7 километр

үргэлжлэх 20 метр хүртлэх өндөр хадан цохио байх бөгөөд түүнийг Хэцүү хад гэнэ. Тэрхүү хадны зарим орой нь уснаас цухуйн гарч гадаад далайн арал мэт үзэсгэлэнтэй сүртэй харагдана. Тэрхүү цухуйж гарсан орой нь усны шувуудын диваажин бөгөөд тэнд үүрээ засаж өндөглөнө. Оросын жуулчин А.В.Бурдуков “Хэцүү хад бол байгалийн гойд сонин тогтоц, үзэсгэлэнт сайхнаараа Монголд хоёрдогч нь юм” хэмээн өөрийн тэмдэглэлдээ бичсэн байдаг билээ.

ХАНХӨХИЙН УУЛС



Ханхөхийн нуруу нь цөл, хээрийн бүс нэмэгдэх үйл явцыг хязгаарладаг экологийн тэнцвэрийг хадгалахад чухал ач холбогдолтой газар юм. Нийт 360 км үргэлжэн орших тус нурууны

орги нь д.т.д 2928м өндөрт орших Дуулга уул юм. Ханхөхийн нуруу нь ой мод, гол горхи, ургамал, амьтан элбэгтэй, байгалийн өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнт газрууд олонтой. Тус нуруунд 61 зүйлийн хөхтөн, 206 зүйлийн шувууд байдгаас гадна ардын уламжлалт эм эмчилгээнд ашигладаг алтан гагнуур, алтан хундага, юмдүүжин, чацсэржим, рэ гомбо, тэхийн шээг, төлөгч өвс, шархны шар, манчин, хөх шар дэгд, ганга, мэхээр, таван салаа зэрэг эмийн ургамлууд, аньс, нохойн хошуу, үхрийн нүд, тошлой, гүзээлзгэнэ, улаалзгана, чацаргана, самар зэрэг жимс жимсгэнэ элбэг ургадаг.

АЛТАН ЭЛС

Увс нуурын хотгорын зүүн хэсэгт орших Бөөрөг дэлийн элсний зүүн хэсгийг Алтан элс гэж нэрлэдэг бөгөөд 177.5 мянган га газрыг эзлэнэ. Энэхүү элс нь дэлхийн бөмбөрцөгийн түрж орсон хамгийн хойд захын элст цэг юм. Хамгийн олон зүлийн ургамал энд ургах төдийгүй, элсэн дороос оргилох булгаас эх аван урсдаг цэнгэг устай гол горхи, булаг шанд, баян бүрдүүд болон гадны нөлөөнд авталгүй, элсэн манхан дунд хадгалагдан үлдсэн говь, хээрийн өвөрмөц эко тогтоцыг хэвээр нь үлдээх зорилгоор Алтан элсийг улсын тусгай хамгаалалтад авчээ. Дундад Ази, Монголын нутаг дахь бусад элсийг бодвол харьцангуй бага талбай эзэлдэг ч байгалийн олон хэв шинжийг хадгалснаараа ялгардаг. Элсний урд хаяа дагуу нарс, шинэс,



чацаргана ургах бөгөөд тухайн орчинг маш үзэсгэлэнтэй болгодог. Алтан элс нь дов толгодлог гадаргатай, элсний зүүн хэсэгт Эрдэнэтөлгой, Залаа толгой, Хөх толгой зэрэг нам уулс шиг толгойнуудтай байгалийн үзэсгэлэнт газар билээ.

ГООЖУУРЫН ХҮРХРЭЭ



Ховд сумын нутагт Монгол Алтайн нурууны салбар уулсын нэг Хархираа, Түргэний уулсын баруун урд Олон нуурын уулсад оршино. Шивэрийн голын зүүн цутгал, Уу-Ширэг хэмээх газарт 17 м өндрөөс унадаг.

Хяргас нуур, Хэцүү хад орчмын аялал жуулчлалын бүсэд байрлах жуулчны баазуудын мэдээлэл

№	Жуулчны баазын нэр	Хаяг байршил	Улаангом-оос км	Холбогдох утас
1	Хэцүү хад	Увс аймаг Завхан сум Хяргас нуур Хэцүү хад	Баруун урагшаа Завхан аймгийн чиглэлд 250 км	99067339 98827339
2	Baruun beach	Увс аймаг Завхан сум Хяргас нуур Хэцүү хад	Баруун урагшаа Завхан аймгийн чиглэлд 250 км	99001903 98851903
3	Өгөөмөр тур Хяргас нуур	Увс аймаг Малчин сум	Улаанбаатар чиглэлд 165 км	95959503 99129948
4	Хяргас нуур	Увс аймаг Хяргас сум Хяргас нуурын хойд талд Довон	Улаанбаатар чиглэлд 145 км	99113907 88076885 98642009
5	Хяргас нуур ресорт	Увс аймаг Малчин сум Могойн гол	Улаанбаатар чиглэлд 145 км	99993990 99960664
6	Хяргас нуур эко бааз	Увс аймаг Наранбулаг сум Хяргас нуурын баруун хойд талд	Улаанбаатар чиглэлд 130 км	99081869, 95454080
7	Хар тэрмис	Увс аймаг Малчин сум Хар тэрмис	Улаанбаатар чиглэлд 145 км	99456796 95910181
8	Жаргалант жуулчны бааз	Увс аймаг Наранбулаг сум	Улаанбаатар чиглэлд 100 км	99128220 95626368 80646368
9	Гэр толгой	Увс аймаг	Ховд сумын чиглэлд 170 км	99456599
10	Цүнхэг	Увс аймаг Түргэн сум Цүнхэгийн ам	Түргэн сумын чиглэлд 40 км	99455828
11	Хүнхийн рашаан /Гивант/	Увс аймаг Зүүнхангай сум Гивантын рашаан	Зүүн урагш чиглэлд 300 км	98112105
12	Мөнгөн давалгаа	Увс аймаг Малчин сум Акаевийн хошуу	Улаанбаатар чиглэлд 115 км	99198475 99795154
13	Агина тур	Увс аймаг Наранбулаг сум Хяргас нуурын баруун хойд талд	Улаанбаатар чиглэлд 130 км	88086774

№	Жуулчны баазын нэр	Хаяг байршил	Улаангом-оос км	Холбогдох утас
14	Баянхайрхан амралт	Увс аймаг Малчин сум Хар тэрмис	Улаанбаатар чиглэлд 145 км	99456530 98454510
15	Тарлаг тур бааз	Увс аймаг, Баруунтуруун сум	Баруунтуруун сум 225 км	86339919 98150609
16	Ногооны рашаан амралт сувилал	Увс аймаг Өмнөговь сум	Ховд аймгийн чиглэлд 130 км	96674369 88674369

Увс нуур, Улаангом хот орчмын аялал жуулчлалын бүсэд байрлах жуулчны баазын мэдээлэл

№	Жуулчны баазын нэр	Хаяг байршил	Улаангом-оос км	Холбогдох утас
1	Увс нуур	Увс аймаг Улаангом сум Увс нуур	Увс нуурын чиглэлд 28 км	99992952 95952952
2	Чандмань тур	Увс аймаг Улаангом сум	Улаан уулын чиглэлд 5 км	99188270 99450966, 98198198,
3	Тээл парк	Увс аймаг Тариалан сум Тээлийн гол	Улаанбаатар чиглэлд 15 км	88275111 99885111 88990219
4	Таван эрдэнэ гэр бааз	Улаангом хот	Улаан уул чиглэлд	99454527 99446991 96566616
5	Улаан уул гэр бааз	Улаангом хот	Улаан уулын дээд талд	99059166

Үүрэг нуур, Хархираа, Түргэний уулсын аялал жуулчлалын бүсэд байрлах жуулчны баазын мэдээлэл

№	Жуулчны баазын нэр	Хаяг байршил	Улаангом-оос км	Холбогдох утас
1	Оршин тогтнохуй	Увс аймаг Түргэн сум Хиргэнэ	Хойд Баян-Өлгий чиглэлд 100 км	99136772 89006772
2	Сүлдэт цахир	Увс аймаг Сагил сум Үүрэг нуурын зүүн урд талд	Хойд Баян-Өлгий чиглэлд 100 км	86691200 89119045 99719948
3	Үүрэг нуур тур бааз	Увс аймаг Сагил сум Үүрэг нуурын хойд талд	Цагаан шувуутын чиглэлд	95405650 99622409
4	Үүргийн долгио	Увс аймаг Сагил сум Үүрэг нуурын зүүн хойд тал Бижийн булаг	Цагаан шувуутын чиглэлд	90871188
5	Үүрэг ресот	Увс аймаг Сагил сум Үүрэг нуурын зүүн урд	Цагаан шувуутын чиглэлд	99459070
6	Одонт Дэглий	Увс аймаг Түргэн сум Бэлчирт	Дэглий цагаан чиглэлд	89805166 99004966
7	Нутгийн жим	Увс аймаг Түргэн сум Эмч	Дэглий цагаан, Үүрэг нуур чиглэлд	89910221 99683701 99450221
8	Ундрал мөнх хайрхан	Увс аймаг Тариалан сум Бага улиас	Тариалан сумын чиглэлд	99454306
9	Байгаль эх	Увс аймаг Тариалан сум Толгойн байгууламж	Тариалан сумын чиглэлд	99458787 99456767
10	Хархираа /том хүн/	Увс аймаг Улаангом сум Хархираан ам	Хархираан уулс чиглэлд 35 км	88058666
11	Хархираа /хүүхдийн зуслан /	Увс аймаг Улаангом сум Хархираан ам	Хархираан уулс чиглэлд 35 км	99452021
12	Их нуур	Увс аймаг Улаангом сум Хархираа ам	Хархираан уулс чиглэлд 35 км	99255265

Зочид буудал

№	Жуулчны баазын нэр	Хаяг байршил	Холбогдох утас
1	Таван Од	N49°59'26.89 E92°03'52.86 Увс аймаг Улаангом 10-р баг	99015928 96897722 99452021
2	Улаангом	N49°58'39.87 E92°04'04.91 Увс аймаг Улаангом 11-р баг	77457171 86457171 99086890
3	Гранд	Увс аймаг Улаангом 10-р баг	99454435 99452996
4	Тэнгэр	Увс аймаг Улаангом 3-р баг	99452269 94244126 99452069
5	Ачит нуур	Увс аймаг Улаангом сум 4-р баг	99452200 70452200 95777896
6	Их наяд	Увс аймаг Улаангом 4-р баг	99452800 99792709
7	Чингис	Увс аймаг Улаангом сум 7-р баг	99459001 99458118 70458118
8	Сарнай	Улаангом сум 3-р баг	99220212 95222021 95455361
9	Mars	Увс аймаг Улаангом 3-р баг	91503050
10	Корунд	Увс аймаг Улаангом хот Биржийн хашаа	88862551 70452561
11	Moon light	Увс аймаг, Улаангом сум, 12-р баг, худалдаа гудамж	77114444 77764444

ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ХУДАЛДААНЫ ГАЗАРУВС АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРМОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАБИМ

БИЗНЕСИЙН СЭРГЭЛТ



ОРОЛЦОГЧИД

ОХУ-ын зочид, төлөөлөгчид

№	Нэрс	Аль муж, байгууллага, албан тушаал
ОХУ-Улаанбаатар		
1.	Васильев Максим Викторович	ОХУ-аас Монгол улсад суугаа Худалдааны төлөөлөгчийн газрын тэргүүн
2.	Кислов Валерий Александрович	ОХУ-ын Худалдаа аж үйлдвэрийн Танхимын хүндэт төлөөлөгч
Тува муж		
3.	Боровикова Марина Павловна	“Сибпродукт” ХХК
4.	Сарыглар Буян Борисович	“Сумбер-Уула” ХХК
5.	Иргит Айдыс Алексеевич	“Агросервис 17” ХХК
6.	Кара-оол Эртине Хомушкевич	СПОК “Агроальянс” ХХК
7.	Желтухин Игорь Александрович	Фермерийн аж ахуй
8.	Ховалыг Алдай-Мерген Алдандайович	Бүгд Найрамдах Тува Улсын Гадаад эдийн засгийн харилцааны агентлагийн захирал
9.	Тулуш Буянзак Мергенович	Бүгд Найрамдах Тува Улсын аялал жуулчлалын агентлагийн захирал
10.	Куулар Айдыс Алексеевич	Овюрскийн дүүргийн захиргааны дарга
11.	Ондар Андрей Вячеславович	Тувагийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Ерөнхийлөгч
12.	Ворона Ольга Викторовна	“Воля” ХХК ерөнхий захирал
13.	Ховалыг Аяна Борисовна	“Тайга-17” ХХК
14.	Ондар Орлан Олегович	Хувиараа бизнес эрхлэгч
15.	Могуш Ульяна Байыр-ооловна	Бүгд Найрамдах Тува Улсын Их Хурлын депутат, Соёлын хамгаалал, нийгмийн хөгжлийн хорооны орлогч
16.	Монге Аяс Норжукаевич	Бүгд Найрамдах Тува Улсын Их Хурлын депутат
Буряд улс		
17.	Дареев Галсан Евгеньевич	Буриад улсын Засгийн газрын орлогч дарга- Хөдөө аж ахуй, хүнсний сайд
18.	Чирипов Даба-Жалсан Шагжиевич	Бүгд Найрамдах Буриад Улсын Монгол Улстай хамтран ажиллах сайд
19.	Гоге Александр Александрович	Буриад улсын Тээвэр, эрчим хүч, замын байгууламжийн хөгжлийн сайд
20.	Раднаев Сергей Ендонович	Жолооч
Алтайн хязгаар		
21.	Терехин Василий Юрьевич	Бүгд Найрамдах Алтайн Төрийн тэргүүний туслах, Бүгд Найрамдах Алтайн Засгийн газрын дарга.
22.	Сницкий Денис Анатольевич	“Криогаз Горный Алтай” ХХК ерөнхий захирал
23.	Горелов Александр Витальевич	“Криогаз Монголия” ХХК гүйцэтгэх захирал
24.	Зоригтбаатар Сунжибаатар	Орчуулагч
25.	Чачияков Айдын Батырович	Жолооч

УЛААНБААТАР ХОТ

1	Бат-Эрдэнэ	Насанжаргал	Би Эф Си Ложистикс ХХК
2	Базарваань	Намжилсүрэн	Цахим байшин ХХК
3	Идэрмөнм	Мөнхзалгамж	Монгол Даатгал ХК
4	Санжмятав	Батцагаан	Монгол даатгал хк
5	Лхагважав	ТӨР-ОД	Монгол Даатгал ХК
6	Гомбо	Мөнхтогтох	Металл маркет ХХК
ХОВД АЙМАГ			
1	Гоёхон урлан	Үндэсний дээл, Оёдол Европ хувцас	Батсүх Чулуунцэцэг
2	Сод эсгий гоёл	Эсгий урлал	Хоролжав Даваасамбуу
3	Баатархайрхан сувинер	Сувинер урлал	Сэдэд Тунгалаг
4	Оёдолчдын холбоо	Зөөлөн оёдол	Зинамядар Нансалмаа
5	Хишиг эрдэнэ баяжих ХХК	Мах махан бүтээгдэхүүн	Доржсүрэн Лхагвасүрэн
6	Ховд эсгий урлан	Эсгий тавчик, сүлжмэл гутал	
7	Тоохуу госон гоёл ХХК	Эсгий гар урлал	Батсүрэн Нямтуяа
8	Сүүн оргил ХХК	Сүү цагаан идээ	Доржхүүгийн Гармаа
9	Олбог ширмэл ширдэг / Манхан сум/	Эсгий, ширмэл	Должин Түмэннасан
10	Ханжаргалант ХХК	Мах махан бүтээгдэхүүн	Эрдэнэ Өлзийхүү
11	Гэрэлт манхан ХХК	Үйлдвэрлэл худалдаа	Насанбат Олонбаяр
12	Хөгжим	Хөгжим зэмсэг	Чадраабал Баатарсүрэн
13	Тунгалаг ус ХХК	Цэвэрлэгээний бодис үйлдвэрлэл	Мичид Бат-Эрдэнэ
14	Мазаалай бренд	Сүү цагаан идээ	Аюуш Баяртуул
15	Тахилгатын нуруу ХХК	Сутай цай	Жанчив Мөнхтунгалаг
16	Электро инстэлейшн ХХК	Мах махан бүтээгдэхүүн	Түвдэндорж Батбуян
17	Ирмүүн чандмань ХХК	Мах махан бүтээгдэхүүн	Бямбадорж Мандалбаяр
18	Оюутогтох ХХК	Сүү, цагаан идээ	Дамдин Оюунхүү
19	Энх хүнс ХХК	Гурил, гурилан бүтээгдэхүүн	Мамад Энхтуяа
20	Уухайт ХХК	Газар тариалан	Даваасүрэн Дуламсүрэн
21	Ховд скай ХХК	Сүү сүүн бүтээгдэхүүн	Самбуу Рагчаа
22	Зөөлөн оёдол	Монгол үндэсний дээл	Олзвий Нансанбуян
23	Аз жаргал урлан	Үндэсний хувцас	Батсүрэн Мөнхбадрал
24	Голден нетворк ХХК	Хэвлэл	Загджав Одончимэга
25	Цэн борголжин ХХК	Тээвэр	Ганбат Баярмаа
26	Зөөлөн бакери	Сувдан шигтгээ шүдний эмнэлэг	Лхагвачулуун Бадамцэцэг

ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ХУДАЛДААНЫ ГАЗАРУВС АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРМОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАБИМ

БИЗНЕСИЙН СЭРГЭЛТ



27	МУХАУТ-ын Ховд салбар танхим	Дарга	Балжаа Ганзориг
28	МУХАУТ-ын Ховд салбар танхим	Менежер	Ганболд Чимэгсүрэн
29	Вестерн холд ХХК	Үйл ажиллагаа хариуцсан захирал	Даваахүү Базаргүрүү
30	Вестерн холд ХХК	Маркетинг борлуулалтын албаны дарга	Батэрдэнэ Довдон
31	Ховд эко цемент	Борлуулалтын менежер	Оюунцэцэг Батсүх
32	Ховд эко цемент	Маркетинг менежер	Лутхүү Амарзаяа
33	Ховд эко цемент	Ерөнхий инженер	Батсуурь Нэргүй
34	Ховд эко цемент	Технологи хэлтэсийн дарга	Саруул Цэлмэг
35	Шинэ ховд үйлдвэр технологийн парк	Хяналтын инженер	Ганбат Анхбаяр
36	Шинэ ховд үйлдвэр технологийн парк	Хяналтын инженер	Энхсайхан Мөнхзориг
37	Шинэ ховд үйлдвэр технологийн парк	Нягтлан	Бумцэнд Даваабал
38	Шинэ ховд Агро парк	Мэргэжилтэн	Нэмэхбаяр Эрдэнэгэрэл
39	Бадамлянхуа гайхмаараа ХХК	Худалдаа, үйлчилгээ	Анка Батбилэг
40	Баянтүм хоршоо	Эсгий урлал	Намсрай Цэрэндолгор
41	Бүжин бренд	Сүү цагаан идээ	Баасанжав Батцэцэг
42	Хашаандаа сайхан амьдаръя	Төсөл	Гансүх Энхцоож
45	Шинэ ховд	Баруун бүсийн корпорацийн дарга	Ширэндэв Батжаргал
УВС АЙМАГ			
2	Сүхбаатар	Бүзэнлхам	Аз жаргал ХХК
3	Нүрзэд	Түмэндэмбэрэл	TD урлан
4	Болдбаатар	Цогт-Очир	Увсчууд.мн сайт
5	Нямдорж	Баярмаа	Хувиараа
6	Төрмөнх	Мянганбаяр	Доньмөнх хайрхан ХХК
7	Бат-Эрдэнэ	Золхүү	Цаст хайрханы цуурай ХХК
8	Хашбаатар	Амгалан	Хатны Улаан ХХК
9	Отгонбаяр	Бадамгарав	Бэрх хоршоо
10	Гомбо	Оюунболд	Монгол даатгал ХХК
11	Пэлжир	Янжи	Энхмандал увс ХХК
12	Чойжоо	Гантуяа	Оренжэри Ган ХХК
13	Сүхбаатар	Бүзэнлхам	Аз жаргал ХХК
14	Нүрзэд	Түмэндэмбэрэл	TD урлан

ЗАВХАН АЙМАГ			
1	Д.Бадамсүрэн	НБХ-ийн дарга	99086842
2	Ц.Бямбажав	Цахим хөгжлийн хэлтсийн дарга	
3	Э.Гүндсамбуу	Арц суурь боомтын захирагч	91919079
4	Д.Мөнхчимэг	Завхан аймаг дахь ХАУТ-ын дарга	99022567
5	С.Ганчимэг	Завхан аймаг дахь ХАУТ-ын гадаад харилцаа харицсан менежер	99469372
6	Б.Энхзаяа	Завхан аймаг дахь ХАУТ-ын менежер	88045261
7	Б.Мөнхзул	ЗДТГ-ын ТЗУХ-ийн Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	85953399
8	Ц.Золзаяа	Мөнхөд Мандаг ХХК	88062511
9	Ч.Ганчимэг	Мөнхөд Мандаг ХХК	
10	Ч.Цэрэндолгор	Мөнхөд Мандаг ХХК	
11	В.Сүнжидмаа	Мөнхөд Мандаг ХХК	
12	Нямбаяр	Завхан баялаг ХХК	89093989
13	Даваажаргал	Завхан баялаг ХХК	
14	П.Жавзанпагма	Завхан аймгийн АЖХ-ны гүйцэтгэл захирал	88671051
15	Оюунбилэг	Цагаанхайрхан сум	95112673
16	Б.Буянжаргал	Тосонцэнгэл сум	88464674
17	А.Төгсжаргал	Тосонцэнгэл сум	88464674
18	Л.Оюунчимэг	Их-Уул сум	97158569
19	Н.Норжмаа	Боролдой номын дэлгүүр	89263640
20	Н.Ганчимэг	ББХТ	88749628
21	Э.Төгсжаргал	Аялал Жуулчлал Газар тариалан	99043017
22	Г.Дэлгэрнавч	хувь хүн	88031359
23	С.Ганзориг	Тосонцэнгэл сум	89582191
24	О.Марзмаа	Тосонцэнгэл сум	95708042
25	Байгаль	Тосонцэнгэл	95708042
26	Б.Банзрагч	Тэс сум	89111931
31	Н.Гомбодорж	Улиастай сум	99468858
32	Б.Даваажаргал	Тосонцэнгэл сум	85666022
33	С.Нямсүрэн	Доной Өгөөж хоршоо	85055500
34	С.Ариунбаяр	Тунадалай ХХК	99102343
35	Ө.Өлзий	Хувь хүн	90969620
36	Б.Пүрэвсүрэн	Хувь хүн	91106869
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ			
1	Х.Бахытгүл	ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга	99428843
2	Х.Муратай	Баян-өлгий аймаг дахь ХАУТ-ын дарга	99422886
3	А.Айнагүл	Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл	99199944
4	А.Гүлмайра	"Асыл мура" ХХК	88026686

“БИЗНЕСИЙН СЭРГЭЛТ-БАРУУН БҮС”

ХӨТӨЛБӨР

Үндсэн зохион байгуулагч: ЭЗХЯ, ХОХГ, Увс аймгийн ЗДТГ, МҮХАУТ
Хамтран зохион байгуулагч: Баруун бүсийн салбар танхимууд
Зочин байгууллага: ОХУ-ын Буриад улс, Тува, Алтайн хязгаар мужийн төлөөлөл
Байршил: Увс аймаг, Улаангом хот
Огноо: 2024.04.26-28-ны өдрүүд

2024.04.26 – 27 (Баасан, Бямба гараг)

**“БИЗНЕСИЙН СЭРГЭЛТ – БАРУУН БҮС ҮЗЭСГЭЛЭН”
Үзэсгэлэн яармагийн нэгдсэн хөтөлбөр**

Хугацаа: 2024 оны 4-р сарын 26-27-ны хооронд
Хаана: Олон улсын худалдааны төв, Улаангом, Увс аймаг

БАРУУН БҮСИЙН ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА

Цаг	Арга хэмжээ	Хариуцагч
4 дүгээр сарын 26, Баасан гараг /Үзэсгэлэнийг нээлт/		
10:00-19:00	Үзэсгэлэн худалдаа	
15.00 – 15.25	Нээлтийн үг	Ч.Чимэд- Увс аймгийн Засаг дарга
		В.Энхбаатар- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Хөрөнгө оруулалт худалдааны газрын дарга
		Тывагийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын ерөнхийлөгч Ондар, Андрей Вячеславович
		С.Сэржим МҮХАУТ-ын Увс аймаг дахь салбар танхимын дарга “Их нуур гом” ХХК-ийн захирал Д.Насанбаяр
15:25-15:40	Хүндэт зочид үзэсгэлэн үзэж сонирхох	
4 дүгээр сарын 27, Бямба гараг		
10.00 – 19.00	Үзэсгэлэн худалдаа олон нийтэд нээлттэй	
13.00 – 14.00	Урлагийн үзүүлбэр	
14.00 – 15.00	Төв тайзан дээр үзэсгэлэнд оролцож буй компаниудын танилцуулга	

**ОХУ-ЫН ЗОЧИД БОЛОН БАРУУН БҮСИЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН УУЛЗАЛТ**

Цаг	Арга хэмжээ	Хариуцагч
4 дүгээр сарын 26, Баасан гараг		
10:00-10:40	Увс аймгийн Засаг дарга болон бизнесийн төлөөллийн уулзалт	Увс аймгийн ЗДТГ, МҮХАУТ
10:40-11:20	Ховд аймаг-ОХУ-ын уулзалт	
11:20-12:00	Завхан аймаг ОХУ-ын уулзалт	
12:00-12:40	Баян Өлгий аймаг ОХУ-ын уулзалт	
13:00	Үдийн зоог	“Таван од” ресторан

2024.04.26 – БААСАН ГАРАГ

БАРУУН БҮСИЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН “SHETRADES HUB MONGOLIA” арга хэмжээний хөтөлбөр

Оролцогчид: Баруун 5 аймгийн бизнес эрхлэгчид
Байршил: Насан туршийн боловсрол хүүхэд хөгжлийн төв
Модератор: С.Баясгалан, МҮХАУТ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга

Цаг	Арга хэмжээ	Хариуцагч
09:00-09:30	Бүртгэл	
09:30-09:40	Нээлтийн үг	Ч.Чимэд- Увс аймгийн Засаг дарга В.Энхбаатар, Хөрөнгө оруулалт, худалдааны газрын дарга
09:40-10:00	SheTrades Hub Mongolia танилцуулга	А.Энэрэл- МҮХАУТ-ын Төсөл Хөтөлбөрийн газрын дарга
10:00-10:15	Women Owned тохирлын танилцуулга	Голомт Банк
10:15-10:30	Азийн Сан - B2B платформ танилцуулга	А.Энэрэл- МҮХАУТ-ын Төсөл Хөтөлбөрийн газрын дарга
10:30-10:50	Цайны завсарлага	Оролцогчид

**“ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАН ЭКСПОРТОО
НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР”**

Цаг	Сэдэв	Хариуцагч
11:00-11:20	МҮХАУТ-ын Хэрэглэгч үйлчилгээний газрын танилцуулга Экспортын бэлэн байдлын үнэлгээ	МҮХАУТ-ын Хэрэглэгч үйлчилгээний газрын дарга Э.Бадамхорол
11:20-11:40	ДХБ-ын Олон улсын худалдааны төвийн “Худалдааны арга хэрэгслийг ашиглах нь”	МҮХАУТ-ын Төсөл, хөтөлбөрийн газрын дарга А.Энэрэл
11:40-12:00	“Худалдааны хоёр болон олон талт хэлэлцээрийг бизнес эрхлэгчид ашиглах боломж”	МҮХАУТ-ын Хэрэглэгч үйлчилгээний газрын ахлах мэргэжилтэн Д.Адъяасүрэн
12:00-12:20	“Экспертизийн үйл ажиллагааны тухай”	МҮХАУТ-ын Хэрэглэгч үйлчилгээний газрын эксперт Ц.Номин-Эрдэнэ
12:20-12:40	Асуулт хариулт	Оролцогчид
12:40-14:00		Өдрийн хоол

“БИЗНЕСИЙН СЭРГЭЛТ – БАРУУН БҮС”

2024.04.27 – Бямба гараг

HARVARD
ManageMentor “МАНЛАЙЛЛЫН ХӨТӨЛБӨР”

Цаг	Сэдэв	Хариуцагч
14:00-15:00	ЁС ЗҮЙТЭЙ МАНЛАЙЛАЛ Бүтээгдээд зориулсан инноваци Бүтээгч харилцаа холбоо тогтоох Инновацийг амьдралд хэрэгжүүлэх Инновацид зориулсан дэмжлэгийг бий болгох Амжилт бүтэлгүйтэл хоёроос суралцах	Д.Ерөө- МУХАУТ-ын дэргэдэх Бизнес академийн зөвлөх
15:00-16:00	НЕТВОРКОО ХӨГЖҮҮЛЭХ Нетворкоо ойлгох Нетворкын зураглал гаргах ба үнэлэх Нетворкоо хүчирхэг болгох арга замуудыг таних нь Харилцаа холбоо тогтоох Нетворкоо ашиглах Нетворкоо тогтвортой хадгалах	С.Баясгалан- МУХАУТ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга
16:00	Сертификат гардуулах ёслолын ажиглалтаа	

Үндсэн зохион байгуулагч:	ЭЗХЯ, ХОХГ, МУХАУТ, Увс аймгийн ЗДТГ
Хамтран зохион байгуулагч:	Увс, Говь-Алтай, Завхан, Баян-Өлгий, Ховд аймгууд дахь салбар танхимууд
Зочин байгууллага:	ОХУ-аас Монгол улсад суугаа Худалдааны төлөөлөгчийн газар, ОХУ-ын Худалдаа, аж үйлдвэрийн төв танхимын Монгол дахь төлөөлөгчийн газар, ОХУ-ын Буриад улс, Тува, Алтайн хязгаар мужуудын төлөөлөл
Оролцогчид:	Увс, Говь-Алтай, Завхан, Баян-Өлгий, Ховд аймгуудын бизнес эрхлэгчид
Байршил:	Увс аймаг, Улаангом хот, 3-р баг, “Аурон” ресторан

ХӨТӨЛБӨР

БИЗНЕСИЙН СЭРГЭЛТ, БАРУУН БҮС
“ЗАЛУУЧУУДАД БИЗНЕСИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ
P-MBA ХӨТӨЛБӨР”

ЗОРИЛГО: 10000 залууд бизнесийн боловсрол олгох замаар бизнес, хөдөлмөр эрхлэхэд чиглүүдэх

Цаг	Сэдэв	Хариуцагч
16:00-16:10	P-MBA “Бизнесийн сэргэлт” үндэсний хөтөлбөрийн танилцуулга P-MBA хөтөлбөрийн онцлог давуу тал Суралцагчийн гарын авлага	Д.Ерөө- МУХАУТ-ын дэргэдэх Бизнес академийн зөвлөх
16:10-16:50	БИЗНЕСИЙН ҮНЭ ЦЭН БҮТЭЭХ НЬ <ul style="list-style-type: none"> • Үнэ цэнийн хүргэлт гэдэг ойлголттой танилцах • Сэтгэл ханамжтай үйлчлүүлэгчийг хэрхэн бий болгодог арга бариод суралцах • Үнэ цэнийн урсгалыг системчлэн сайжруулахын ач холбогдлыг мэдэх 	МУХАУТ-ын дэргэдэх Бизнес академи
16:50-17:30	БУСАДГАЙ АЖИЛЛАХ НЬ <ul style="list-style-type: none"> • Бусадтай хэрхэн үр дүнтэй харилцах • Бусдын хүндлэл, итгэлийг олох • Харилцаанд тулгардаг хүндэрэл бэрхшээлийг таниж мэдэх • Багийг амжилттай удирдаж, манлайлах 	МУХАУТ-ын дэргэдэх Бизнес академи
17:30-18:10	БИЗНЕСИЙН СИСТЕМИЙГ ОЙЛГОХ НЬ <ul style="list-style-type: none"> • Системийн тухай заавал мэдэх ойлголтууд • Системд тулгардаг асуудлууд • Галлын хууль 	А.Эвэрэл- МУХАУТ-ын Төсөл Хөтөлбөрийн газрын дарга
18:30	Хүндэтгэлийн хүлээн авалт (Таван-Од ресторан)	МУХАУТ

Нээлт: Хөтөлгөч: МУХАУТ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Баясгалан	
09:00-09:30	Бүртгэл /орон нутгийн цагаар/
09:30-09:40	Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар
09:40-09:50	ОХУ-аас Монгол Улсад суугаа Худалдааны төлөөлөгчийн газрын тэргүүн Васильев Максим Викторович
09:50-10:00	Увс аймгийн засаг дарга Ч.Чимэд
10:00-10:10	Ховд аймгийн засаг дарга Э.Болормаа
Танилцуулга илтгэл:	
10:10-10:25	“Баруун бүсийн хөгжил, худалдаа, хөрөнгө оруулалтын боломж” Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар
10:25-10:40	“Танхимуудын хамтын ажиллагаа” Худалдаа аж үйлдвэрийн Танхимын хүндэт төлөөлөгч ноён Кислов Валерий Александрович
10:40-10:55	“Баруун бүсийн бизнесийн орчин” МУХАУТ-ын дэд захирал Ц.Магтайбаатар
10:55-11:10	“Тыва Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим” танилцуулга Тывагийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын ерөнхийлөгч Ондар, Андрей Вячеславович
11:10-11:25	<i>Цайны завсарлага</i>
11:25-12:10	Панел хэлэлцүүлэг: “БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ, ХУДАЛДАА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН” Модератор: ХОХГ-ын дарга В.Энхбаатар
12:10-12:40	Асуулт, харуулт
12:40-12:45	“Women owned” тохирлын гэрчилгээ гардуулах (5 аймгийн төлөөлөл)
12:45-12:55	“ХАМТЫН АЖИЛЛАГА АНЫ САНАМЖ БИЧИЙ” ЗУРАХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА
13:30-14:30	<i>Үдийн зоог /Урлагийн тоглолт/</i>



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ХУДАЛДААНЫ ГАЗАР



УВС АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР



МОНГОЛЫН ҮНДСЭНИЙ
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНДИМ

2024.04.27 – Бямба гараг

B2B уулзалт:		
Компаниудын танилцуулга / Төслийн танилцуулга / Бизнес уулзалт		
14:30-14:40	Увс аймгийн аялал жуулчлалын танилцуулга	Аурон ресторан
14:40-14:55	ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ТАНИЛЦУУЛГА “Увс хүнс” ХХК “Ханбогд” ХХК	Аурон ресторан
14:55-16:30	Компаниудын танилцуулга, B2B уулзалт	Бага танхим (Аурон)
18:00-20:00	Хүндэтгэлийн хүлээн авалт (ХОХГ) Увс аймгийн нэрийн брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн, танилцуулга СОЁЛ УРЛАГИЙН ТОГЛОЛТ	Аурон ресторан

2024.04.28 Ням гараг

Цаг	Арга хэмжээ
10:00-13:00	- Увс хүнс ХХК /Үйлдвэртэй танилцуулга/ - Хяргас нуур үзэх

~000~



АМТА ЧАЦАРГАНЫ ӨТГӨРҮҮЛСЭН ШҮҮС


Дэлхийн шим мандлын өв нутаг Увс нуурын ай сав газар ургадаг чацаргана одоо “Увсын чацаргана” газарзүйн заалтай болж бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чанарын ISO 22000 стандартыг амжилтай хэрэгжүүлсэн. Амта нэрийн бүтээгдэхүүн боллоо. Бусад бус нутгийн чацарганаас 3 дахин илүү витамин С агуулдаг ба А, Е, К витамин агууламжаар онцгой бүтээгдэхүүн юм. Мэдээж омега 3, 6 бас бий. Амта шүүснээс чацаргана жимсний өвөрмөц, онцгой, исгэлэн амтыг та мэдрэх болно. Хүйтнээр уувал янзтай.

+976 75558686 Увс Хүнс ХК/ Uvs Khuns JSC uvskhuns.mn





+976 99101560 +976 99101560



“ИХНУУРГОМ” ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ “Орлогын бүтээн байгуулалт” уриалга гарган иргэдээ сэдэлжүүлж төрийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдүүлж иргэдээс гарах зардлыг бууруулах, баялаг бүтээгч, бизнес эрхлэгчдийг шаардлагатай дэд бүтэц, техник тоног төхөөрөмж, санхүүгийн эх үүсвэр, маркетинг менежментээр дэмжин шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх брэнд хөгжүүлэлтэд суурилсан ажлын байр бий болгох кластерийг хөгжүүлж орлого бүтээж ажиллалаа.

Увс аймгийн нөөцөд суурилсан эдийн засгийн бие даан байдлыг хангах “Олон улсын худалдаа тээвэр логистик”, “Баруунтуруун ХАА–н цогцолбор”, Хөдөөгийн сэргэлт төвлөрлийг сааруулах “Шинэ суурьшлын бүс”, Олон улсын глобал сургуульд суурилсан шинэ хотын төлөвлөлтийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан тооцоо судалгааг хийх, хөрөнгө оруулалтыг татах ажлыг эхлүүлээ.



Монгол Улсын Засгийн газрын “Боомтын сэргэлт” бодлогын хүрээнд баруун бүсийн аймгуудын боомтуудад өргөтгөл шинэчлэл хийгдэж байгаа энэ үед “Хөдөөгийн сэргэлт–Бүсчилсэн хөгжлийн бодлого”–ыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Эдийн засгийн хөгжлийн яам, Хөрөнгө оруулалт, худалдааны газар, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран Увс аймгийн Засаг даргын тамгын газар “Бизнесийн сэргэлт–Баруун бүсэд” Олон улсын арга хэмжээг анх удаа зохион байгуулж байна. Уг арга хэмжээ нь бүс нутгийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, хил орчмын Улсуудын бизнес, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргасан, харилцан үр ашигтай хөрөнгө оруулалтыг бий болгох чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Баруун бүс нутагт орлого бий болгох хил дамнанас бүс нутгийн эдийн засгийн форумыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан ЭЗХЯ, ХОХГ, МҮХАҮТ–ын удирдлага хамт олонд Увс нутгийнхаа бүтээлч иргэдийн нэрийн өмнөөс баярласнаа илэрхийлж байна.



Thank you for choosing Sustainable Mongolian Cashmere

Nomadic heritage
Luxury
Timeless
Beauty



KHANBOGD CASHMERE LLC
Seoul Business center #406, Zaluuchud Avenue-26, Bayanzurkh district, Ulaanbaatar, Mongolia | Tel:(976) - 7272-0666, Fax:(976) - 11 454-236
Email: cashmere@khanbogd.mn
www.khanbogdcashmere.com | www.khanbogd.mn



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМ



ХӨДӨЛМӨР
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
БОЛОВСРОЛ ХӨДӨЛМӨР ЭРКЛЭГИЙГ ДЭМЖИХ САН

БИЗНЕСИЙН СЭРГЭЛТ ХӨТӨЛБӨР 10.000



65% Танхимаар



35% Онлайн

'Personal MBA'

- Хичээл 1 ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭ ЦЭН БҮТЭЭХ НЬ
- Хичээл 2 МАРКЕТИНГ
- Хичээл 3 БОРЛУУЛАЛТ
- Хичээл 4 ХЭРЭГЛЭГЧДЭД ҮНЭ ЦЭН ХҮРГЭЛТ
- Хичээл 5 САНХҮҮ
- Хичээл 6 ХҮНИЙ ОЮУН УХААН
- Хичээл 7 ӨӨРТЭЙГЭЭ АЖИЛЛАХ НЬ
- Хичээл 8 БУСАДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ НЬ
- Хичээл 9 СИСТЕМИЙГ ОЙЛГОХ
- Хичээл 10 СИСТЕМД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ
- Хичээл 11 СИСТЕМИЙГ САЙЖРУУЛАХ НЬ
- Хичээл 12 БИЗНЕС ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

Эхний элсэлт 4-р сарын 13


99.000 ₮

БҮРТГЭЛИЙН
ХОЛБООС



ЗААВАР

- 1 www.mongolchamber.mn
- 2 10.000 ЗАЛУУС БҮРТГЭЛ цэсээр орно
- 3 БҮРТГҮҮЛЭХ товчийг дарна



10.000

ЗАЛУУСЫН
БИЗНЕСИЙН
СУРГАЛТ

1.000

ЗАЛУУС
ОЛОН УЛСЫН
БИЗНЕСИЙН
СУРГАЛТАНД
ХАМРАГДАНА



100

БИЗНЕСИЙГ
БОЙЖУУЛНА

3+



ХӨРӨНГИЙН
ЗАХ ЗЭЭЛД
ГАРГАНА

www.mongolchamber.mn

БИЗНЕСИЙН СЭРГЭЛТ

БАРУУН
БҮСИЙН
ФОРУМ